



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 5156

Дуурсах

С.Батцэцэг, Б.Болормаа нарт
Урамшуулал олгох тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Журам батлах тухай” А/135 дугаар тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 631 дүгээр албан бичгийн хүрээнд эрүүл мэндийн статистикийн 2021 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр “95.6” хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга С.Батцэцэг, Эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан бага эмч Б.Болормаа нарт 1 сарын үндсэн цалингийн 40 хувиар тус бүрт урамшуулал олгосугай.
2. Урамшуулалд зарцуулагдах зардлыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ

